



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/99

Мандалговь

“Аркосис” ХХК-тай гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”- 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн А/61 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Дэлгэрхангай, Дэрэн сумын ерөнхий боловсролын шинэ сургуульд тавилга, тоног төхөөрөмж” нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Аркосис” ХХК-тай 25,652,000 (хорин таван сая зургаан зуун тавин хоёр мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг, төсвийн дагуу “Дэлгэрхангай, Дэрэн сумын ерөнхий боловсролын шинэ сургуульд тавилга, тоног төхөөрөмж” ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Аркосис” ХХК-ийн захирал (Б.Чадраабал)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (А.Нарантуяа), Боловсрол, соёл, урлагийн газрын даргыг түр орлон гүйцэтгэгч (А.Мөнхтуяа), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060406